



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА

2024 оны 09 дугаар сарын 09-ны өдөр

**ОРОН НУТГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРМЫН ЗАРИМ ЗҮЙЛ ХЭСГҮҮДИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД АУДИТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

1.1. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Улсын бүртгэлийн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журмын"-ын 14 дугаар зүйлийн 14.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/576 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ын хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохион, байгуулах, захиргаа болон албан хаагчийн хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулахад "Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа эсэхэд дотоод аудит хийж илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх замаар цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2.1. Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Увс аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийн төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн систем болон хүний нөөцийн удирдлагын системд төлөвлөгөөт шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал ажлын 10 өдөрт хийж гүйцэтгэнэ.

2.2. Шаардлагатай тохиолдолд хугацаанд өөрчлөлт оруулж болно.

2.3. 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулна.

**Гурав. Дотоод аудитын
ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

3.1.Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нар ажиллана.

3.2. Дотоод аудит хийгдэх хугацаанд холбогдох хэлтсийн дарга, хариуцсан албан хаагч нар нь шаардлагатай баримт бичиг, мэдээллээр хангах үүргийг хариуцна.

Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэл

4.1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын дор дурдсан зүйл, хэсгүүдийн хэрэгжилтэд дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэнэ:

Амралт, түр чөлөө, тэтгэмж, тусламж

- Хөдөлмөрийн дотоод журмын- 8.1
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.2
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.3
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.7
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.8
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.10
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.15
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.15.1
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.15.3
- Хөдөлмөрийн дотоод журмын -8.15.

Шагнал, урамшуулал

- Хөдөлмөрийн дотоод журмын-9.1
- Хөдөлмөрийн дотоод журмын-9.1.1
- Хөдөлмөрийн дотоод журмын-9.2.1

Ажлын хариуцлага

- Хөдөлмөрийн дотоод журмын-10.1
- Хөдөлмөрийн дотоод журмын-10.8

Тав.Үүрэг, хариуцлага

5.1. Дотоод аудитад хамрагдаж буй Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсүүд дараах үүрэг, хариуцлага хүлээж оролцоно.

5.1.1. Шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх;

5.1.2. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл боломжоор хангах;

5.1.3. Дотоод аудитын ажлын баримттай танилцаж, санал, тайлбар өгөх;

5.1.4. Ажлын хэсгээс гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

5.2. Дотоод аудитын ажлын хэсэг дараах үүрэг, хариуцлага хүлээж оролцоно.

5.2.1. Дотоод аудит хийхдээ удирдамжийн хүрээнд ажиллах;

5.2.2. Дотоод аудитад хамрагдаж буй хэлтэст хүндрэл учруулахгүй байх;

5.2.3. Дотоод аудитын ажлын явцад хэлтсийн мэдээллийн нууцыг хадгалах;

5.2.4. Дотоод аудитын тайлангийн төслийг холбогдох албан тушаалтанд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл залруулга хийх;

5.2.5. Дотоод аудитын дүрмийг баримтлан, бие даасан байдалтай гүйцэтгэх;

5.2.6. Тодорхой асуудлуудын хүрээнд нөхцөл байдлыг ойлгох зорилгоор дэлгэрэнгүй асуулгын хуудас ашиглан асуулга авах;

5.2.7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын дүнг танилцуулах

6.1 Дотоод аудитыг хийж гүйцэтгэснээс хойш ажлын 3 өдрийн дотор илтгэх хуудсаар Ерөнхий газрын даргад танилцуулна.

6.2. Дотоод аудитад хамрагдсан Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж, албан даалгавар хүргүүлнэ. Хэрэгжилтийг хангаж, алдаа, дутагдлыг хэрхэн арилгасан талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тогтоосон хугацаанд Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газарт ирүүлнэ.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР